ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**Аудитын код: ХОА**-2022/23/**НА/-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn
Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Б.Должинжав
Утас: 89898557
цахим хаяг: Doljinjavb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудит санал дүгнэлт ... 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл... 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 9
3. Аудитын тайлан ... 9
3.1 Ерөнхий зүйл ... 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт... 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ... 10
3.4 Материаллаг байдал ... 10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ... 10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ... 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг... 12
3.8 Аудитын гол асуудал ... 12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ... 12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт... 12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт... 12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал... 12
4. Аудитын илрүүлэлт... 13
4.1 Залруулсан алдаа ... 13
4.2 Зөвлөмж ... 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ... 13

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| НА | Нотлох ажил |

## 1.Аудит санал дүгнэлт

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.21 № 2/44
танай ____________-ны № ____________-т

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА П.ЭРДЭНЭЧУЛУУН ТАНАА

**ЗӨРЧИЛГҮЙ ДҮГНЭЛТ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

# 2.**Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

## 2.1 **Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Төгрөгөөр

| Дансны код | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 87,356,978.58 | 55,301,751.68 |
| 33 | АВЛАГА | 7,338,796.58 | 1,127,422.18 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 5,089,750.00 | 754,450.00 |
| 335 | Бусад авлага | 2,249,046.58 | 372,972.18 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 2,249,046.58 | 372,972.18 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 80,018,182.00 | 54,174,329.50 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 78,184,950.00 | 45,428,329.50 |
| 354 | Хангамжийн материал | 1,833,232.00 | 8,746,000.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,176,500.00 | 1,956,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 561,601.00 | 130,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.00 | 6,600,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 95,131.00 | 60,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,434,279,226.19 | 1,438,698,057.33 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,434,279,226.19 | 1,438,698,057.33 |
| 392 | Биет хөрөнгө | 1,413,982,426.19 | 1,418,401,257.33 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,282,063,203.00 | 1,282,063,203.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -76,808,841.66 | -99,467,505.11 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 91,723,412.00 | 147,723,412.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -91,723,412.00 | -96,400,727.30 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 163,456,047.80 | 217,873,037.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -146,230,457.15 | -158,434,353.02 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 11,410,059.10 | 11,410,059.10 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,682,100.91 | -11,059,338.07 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 849,838,093.60 | 849,838,093.60 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -659,063,577.59 | -725,144,624.67 |
| 393 | Биет бус хөрөнгө | 20,296,800.00 | 20,296,800.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 20,681,800.00 | 20,681,800.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -385,000.00 | -385,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** III=I+II | 1,521,636,204.77 | 1,493,999,809.01 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 3,008,448.50 | 0.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 3,008,448.50 | 0.00 |
| 413 | Өглөг | 3,008,448.50 | 0.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,773,448.50 | 0.00 |
| 4136 | Бусад өглөг | 1,235,000.00 | 0.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,235,000.00 | 0.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,518,627,756.27 | 1,493,999,809.01 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,518,627,756.27 | 1,493,999,809.01 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 425,172,962.00 | 425,172,962.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 425,172,962.00 | 425,172,962.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,060,952,557.61 | 1,036,324,610.35 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,036,669,355.96 | 1,060,952,557.61 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 24,283,201.65 | -24,627,947.26 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 32,502,236.66 | 32,502,236.66 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 1,521,636,204.77 | 1,493,999,809.01 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын зүйл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 1,451,953,415.00 | 1,413,557,839.50 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 175,414,115.00 | 185,273,639.50 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 175,414,115.00 | 185,273,639.50 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 175,414,115.00 | 185,273,639.50 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 70,874,650.00 | 90,056,550.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 104,539,465.00 | 95,217,089.50 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,276,539,300.00 | 1,228,284,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,276,539,300.00 | 1,228,284,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,250,839,300.00 | 1,227,406,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 25,700,000.00 | 878,000.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 1,427,670,213.35 | 1,438,185,786.76 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,427,670,213.35 | 1,438,185,786.76 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,228,819,970.48 | 1,263,285,336.43 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 728,695,546.65 | 759,423,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 528,471,796.16 | 496,818,325.86 |
| 210102 | Нэмэгдэл | 174,950,716.49 | 213,629,374.14 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 25,273,034.00 | 48,976,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 97,873,432.40 | 102,522,199.46 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 84,635,701.50 | 72,145,300.01 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,326,175.91 | 7,594,199.99 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгал | 2,667,888.12 | 6,075,400.16 |
| 210204 | Ажилгүйдлын даатгал | 658,515.21 | 1,518,799.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,585,151.66 | 15,188,499.53 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 56,409,300.00 | 56,260,341.21 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 8,678,600.00 | 5,854,639.21 |
| 210302 | Түлш, халаалт | 43,451,660.00 | 47,656,040.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,257,940.00 | 2,534,962.00 |
| 210304 | Байрны түрээс | 21,100.00 | 214,700.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 75,519,868.00 | 63,249,507.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,776,900.00 | 13,233,073.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,461,000.00 | 35,960,779.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 12,324,800.00 | 11,858,355.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,192,620.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,644,548.00 | 2,077,300.00 |
| 2105 | Нормативт зардал | 23,476,600.00 | 61,891,470.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 21,226,600.00 | 58,185,720.00 |
| 210502 | Хоол, Хүнс | 2,250,000.00 | 3,705,750.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 63,754,793.70 | 50,845,634.90 |
| 210604 | Урсгал засвар | 63,754,793.70 | 50,845,634.90 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 28,457,000.00 | 17,782,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 28,457,000.00 | 17,782,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 28,089,350.00 | 44,411,825.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 23,410,850.00 | 41,010,950.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 651,500.00 | 582,175.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 110,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,905,000.00 | 1,538,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 12,000.00 | 5,200.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,000,000.00 | 1,242,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 126,544,079.73 | 106,898,158.86 |
| 210902 | Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх | 975,000.00 | 900,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал | 125,569,079.73 | 105,998,158.86 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 198,850,242.87 | 174,900,450.33 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 86,469,700.00 | 81,955,693.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 0.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 86,469,700.00 | 81,955,693.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 112,380,542.87 | 92,944,757.33 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 112,380,542.87 | 92,944,757.33 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 24,283,201.65 | -24,627,947.26 |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | 24,283,201.65 | -24,627,947.26 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 4-01 | 2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 425,172,962.00 | 32,502,236.66 | 1,036,669,355.96 | 1,494,344,554.62 |
| 4-03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 425,172,962.00 | 32,502,236.66 | 1,036,669,355.96 | 1,494,344,554.62 |
| 4-08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 24,283,201.65 | 24,283,201.65 |
| 4-01 | 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 425,172,962.00 | 32,502,236.66 | 1,060,952,557.61 | 1,518,627,756.27 |
| 4-03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 425,172,962.00 | 32,502,236.66 | 1,060,952,557.61 | 1,518,627,756.27 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4-08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -24,627,947.26 | -24,627,947.26 |
| 4-01 | 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 425,172,962.00 | 32,502,236.66 | 1,036,324,610.35 | 1,493,999,809.01 |

## 2.4 **Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,347,324,500.00 | 1,318,340,750.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 70,785,200.00 | 90,056,550.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 70,785,200.00 | 90,056,550.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 70,785,200.00 | 90,056,550.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 70,785,200.00 | 90,056,550.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,276,539,300.00 | 1,228,284,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,250,839,300.00 | 1,227,406,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,250,839,300.00 | 1,227,406,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 25,700,000.00 | 878,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 25,700,000.00 | 878,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,347,324,500.00 | 1,318,340,750.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,330,324,500.00 | 1,273,923,760.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,131,474,257.13 | 1,099,023,309.67 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 727,571,077.21 | 759,423,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 527,347,326.82 | 496,818,325.86 |
| 210102 | Нэмэгдэл | 174,950,716.39 | 213,629,374.14 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 25,273,034.00 | 48,976,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 98,903,499.92 | 102,522,199.46 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 98,903,499.92 | 72,145,300.01 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.00 | 7,594,199.99 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.00 | 6,075,400.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.00 | 1,518,799.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0.00 | 15,188,499.53 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 56,409,300.00 | 56,260,341.21 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,678,600.00 | 5,854,639.21 |
| 210302 | Түлш, халаалт | 43,451,660.00 | 47,656,040.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,257,940.00 | 2,534,962.00 |
| 210304 | Байрны түрээс | 21,100.00 | 214,700.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 73,179,840.00 | 63,403,334.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,776,900.00 | 13,276,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,461,000.00 | 35,960,779.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,324,800.00 | 11,968,355.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,497,140.00 | 2,077,300.00 |
| 2105 | Нормативт зардал | 23,476,600.00 | 23,854,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 21,226,600.00 | 21,226,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2,250,000.00 | 2,628,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 87,385,940.00 | 29,638,410.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 583,010.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 76,286,540.00 | 20,992,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,099,400.00 | 8,063,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 32,792,300.00 | 17,782,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 32,792,300.00 | 17,782,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 30,379,800.00 | 44,762,325.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 24,165,300.00 | 38,556,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,536,000.00 | 1,536,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 261,000.00 | 261,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 390,500.00 | 390,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 110,000.00 | 108,025.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,905,000.00 | 1,905,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 12,000.00 | 5,200.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,375,900.00 | 1,375,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,375,900.00 | 1,375,900.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 198,850,242.87 | 174,900,450.33 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 86,469,700.00 | 81,955,693.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 64,169,700.00 | 77,844,693.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22,300,000.00 | 4,111,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 112,380,542.87 | 92,944,757.33 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 112,380,542.87 | 92,944,757.33 |
| 4 | ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 17,000,000.00 | 44,416,990.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 17,000,000.00 | 44,416,990.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 17,000,000.00 | 44,416,990.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 17,000,000.00 | 44,416,990.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 17,000,000.00 | 44,416,990.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -17,000,000.00 | -44,416,990.00 |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 7 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 0.00 | 0.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Код | Эдийн засгийн ангилал | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,227,406,200.00 | 1,224,517,992.67 | 2,888,207.33 |
| | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,227,406,200.00 | 1,224,517,992.67 | 2,888,207.33 |
| | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,145,450,500.00 | 1,142,562,299.67 | 2,888,200.33 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 759,423,700.00 | 759,423,700.00 | 0.00 |
| 210101 | Үндсэн цалин | 554,962,900.00 | 496,788,325.86 | 58,174,574.14 |
| 210102 | Нэмэгдэл | 24,805,000.00 | 48,976,000.00 | -24,171,000.00 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 179,655,800.00 | 213,659,374.14 | -34,003,574.14 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 102,522,200.00 | 102,522,199.46 | 0.54 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 72,145,300.00 | 72,145,300.01 | -0.01 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,594,200.00 | 7,594,199.99 | 0.01 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,075,400.00 | 6,075,400.16 | -0.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,518,800.00 | 1,518,799.77 | 0.23 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,188,500.00 | 15,188,499.53 | 0.47 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 58,747,500.00 | 56,260,341.21 | 2,487,158.79 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,942,000.00 | 5,854,639.21 | 2,087,360.79 |
| 210302 | Түлш, халаалт | 47,736,800.00 | 47,656,040.00 | 80,760.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,796,000.00 | 2,534,962.00 | 261,038.00 |
| 210304 | Байрны түрээс | 272,700.00 | 214,700.00 | 58,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 63,260,000.00 | 62,903,334.00 | 356,666.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,276,900.00 | 13,276,900.00 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,461,000.00 | 35,460,779.00 | 221.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,324,800.00 | 11,968,355.00 | 356,445.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,077,300.00 | 2,077,300.00 | 0.00 |
| 2105 | Нормативт зардал | 23,476,600.00 | 23,476,600.00 | 0.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 21,226,600.00 | 21,226,600.00 | 0.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2,250,000.00 | 2,250,000.00 | 0.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 74,063,200.00 | 74,055,400.00 | 7,800.00 |
| 210406 | Багаж, техник, хэрэгсэл | 45,000,000.00 | 45,000,000.00 | 0.00 |
| 210406 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 21,000,000.00 | 20,992,200.00 | 7,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,063,200.00 | 8,063,200.00 | 0.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 17,792,300.00 | 17,782,500.00 | 9,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,792,300.00 | 17,782,500.00 | 9,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 44,789,100.00 | 44,762,325.00 | 26,775.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,574,600.00 | 38,556,600.00 | 18,000.00 |
| 210801 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,536,000.00 | 1,536,000.00 | 0.00 |
| 210801 | Даатгалын үйлчилгээ | 261,000.00 | 261,000.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 390,500.00 | 390,500.00 | 0.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 110,000.00 | 108,025.00 | 1,975.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,905,000.00 | 1,905,000.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 12,000.00 | 5,200.00 | 6,800.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,375,900.00 | 1,375,900.00 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 1,375,900.00 | 1,375,900.00 | 0.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 81,955,700.00 | 81,955,693.00 | 7.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 81,955,700.00 | 81,955,693.00 | 7.00 |
| 213209 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 77,844,700.00 | 77,844,693.00 | 7.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,111,000.00 | 4,111,000.00 | 0.00 |
| 213300 | Улсын төсвөөс олосон санхүүжилт,шилжүүлэг | 0.00 | 2,888,207.33 | -2,888,207.33 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 2,888,207.33 | -2,888,207.33 |
| 1 | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,227,406,200.00 | 1,224,517,992.67 | |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,227,406,200.00 | 1,224,517,992.67 | 0.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,227,406,200.00 | 1,224,517,992.67 | 2,888,207.33 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын тайлан, төсвийн зарцуулалт, тайлагналтай холбоотой асуудлаар зөвлөмж өгсөн болно.

Аудитыг аудитор Б.Должинжав 2022 оны 02 дугаар сарын 15-аас 02 дугаар сарын 19–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн 47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мэргэжлийн хяналтын газар нь “МУ-ын холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар үндэсний аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдолоос хамгаалуулах чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэх хөдөлмөрлөх эрхийг хангах, бизнес эрхлэгчдэд хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх” эрхэм зорилгын хүрээнд “Дижитал шилжилт-хэрэглэгчтэй хамтарсан хяналт ” зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Чиг үүрэг: Хууль тогтоомж хэрэгжүүлэгч, хяналт шалгалт хийх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт оржээ. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"*
- *Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар "Төсвийн зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"*

Тухайн онд байгууллагын МХЕГ-ын дотоод аудитын албанаас санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллажээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2016 оны А/171 тушаалаар баталсан салбар байгууллагуудын хэмжээнд нэгдсэн журмаар мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тухайн байгууллага санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 **Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар бүртгэж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлан гэж үнэлсэн.

### 3.4 **Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн үнэлгээнээс хамаарч материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "бага" гэж үнэлсэн учир материаллаг байдлын түвшинг хамгийн ихээр буюу 2 хувиар тогтоосон.

Материаллаг байдлын түвшинг 2021 оны батлагдсан төсөв 1,227,406.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 24,548.1 мянган төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 19,638.5 мянган төгрөгөөр тогтоов.

### 3.5 **Санхүүгийн тайлангийн тодруулга**

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27,636.4 мянган төгрөгөөр буурсны материаллаг нөлөө нь бараа материалын данстай холбоотой байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Өмнөх оны үзүүлэлтэй харьцуулахад дансны авлагын үлдэгдэл 6,211.4 мянга, бараа материалын үлдэгдэл 25,843.9 мянган төгрөгөөр тус тус буурч, үндсэн хөрөнгийн цэвэр дүн 4,418.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны оны эхний үлдэгдэл 7,338.7 мянган төгрөг байсан бол оны эцэст 1,127.4 мянган төгрөг болж 6,211.3 мянган төгрөгөөр буурсан байна. Эцсийн үлдэгдэл дэх 1,127.4 мянган төгрөгийн 372.9 мянган төгрөг нь НДШ-ийн авлага, 754.4 мянган төгрөг нь ажилчидтай холбогдсон авлага байна.

Бараа материал дансны эхний үлдэгдэл 80,018.2 мянган төгрөг байсан бол оны эцэст 54,174.3 мянган төгрөг болж 25,843.8 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 105,732.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 29,217.1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, 160,793.0 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 2,419,172.6 мянган төгрөг байсан бол оны эцэст 2,529,589.6 мянган төгрөг болж 110,416.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Төсвийн хөрөнгөөр 44,416,9 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж худалдан авч, улсын нөөцөөс 36000.0 мянган төгрөгийн УАЗ пургон, 20000.0 мянган төгрөгийн Hyundai Starex маркын авто машин, 10000.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Тайлант оны эхэнд 3,008.4 мянган төгрөгийн өр төлбөртэй байсан бол тухайн онд бүрэн барагдуулж, оны эцэст өргүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 1,518,627.7 мянган төгрөг байсан ба оны эцэст 1,493,999.8 мянган төгрөг болж 24,627.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд нөлөөлсөн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, залруулах бичилт хийгдээгүй байна.

### 3.6 **Төсвийн төлөвлөлт**, **гүйцэтгэл**, **нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 **Төсвийн төлөвлөлт**

Мэргэжлийн хяналтын газар төсвийн төсөлд 2021 оны нийт зардлыг 1,305,948.0 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,305,948.0 мянган төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба дээд шатны төсвийн захирагч тус байгууллагад 1,227,406.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталжээ.

#### 3.6.2 **Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр 1,227,406.2 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс бүрэн авч, урсгал үйл ажиллагаанд 1,224,518.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулагдаагүй 2,888.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,224,518.0 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,487.2 мянга, хангамж, бараа материалын зардлыг 356.7 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 7.8 мянга, томилолт, зочны зардлыг 9.8 мянга, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 28.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 **Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу төсвийн байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар МХЕГ-аас нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх хяналт шалгалтын шатахуун, томилолтын зардлын санхүүжилт 878.0 мянган төгрөг орсон ба, дээрх эх үүсвэрийг зориулалтын дагуу холбогдох үйл ажиллагаанд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй дараах асуудал байна.

. Төсвийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэх үндсэн үйл ажиллагааны орлого 90,056.5 мянган төгрөг бүрдүүлснээс 75575.0 мянган төгрөг буюу 84 хувийг Мо Эн Ко ХХК-д тээврийн хэрэгслийн ариутгал халдваргүйжүүлэлтийн үйлчилгээний хөлс байна.
2. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 38556.6 мянган төгрөг зарцуулснаас 14774.6 мянган төгрөгийг ажилчдын эрүүл мэндийн үзлэгийн төлбөрт зарцуулсан байна.

**3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

3.9 **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим системд санхүүгийн тайлан хагас, бүтэн жилээр, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний дүнг дутуу мэдээлсэн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хэсэгт цалингийн ашиг, НДШ-д төлсөн зарим зарлагыг мэдээлсэн, төсвийн байгууллагын батлагдсан төсөв гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбаргүй зэрэг зөрчлийг шалгагдагч байгууллага аудитын явцад залруулла.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 20243.4 мянган төгрөгийн төлбөрийн 3 актаас 15473.3 мянган төгрөгийн актыг барагдуулж, ажилчидтай холбоотой 2881.6 мянган төгрөгийн актыг хүлээн зөвшөөрөхгүй тайлбарыг тус аудитын газар албан тоотоор хүргүүлсэн ба 1888.5 мянган төгрөгийн төлбөрийн актын үлдэгдэлтэй байна. Өмнөх оны СТА-аар өгсөн 3 зөвлөмжөөс 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй ба аудитын явцад зөрчлийг арилгууллаа.

3.11 **Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2549.0 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 1 зөрчлийг аудитын явцад залруулж, 2549.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Шилэн дансны цахим системд санхүүгийн тайлан хагас, бүтэн жилээр, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний дүнг дутуу мэдээлсэн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хэсэгт цалингийн ашиг, НДШ-д төлсөн зарим зарлагыг мэдээлсэн, төсвийн байгууллагын батлагдсан төсөв гүйцэтгэлийн  хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбаргүй зэрэг зөрчлийг шалгагдагч байгууллага аудитын явцад арилган 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлэв.

***Шийдвэрлэсэн нь***: Зөрчлийг аудитын явцад залруулсан алдаанд бүртгэж тайлагнав.

### 4.2 **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Бараа материалын данстай  холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Бараа материалын тайланд анхан шатны баримтаарх дүнгээс илүү, дутуу зарлагадаж тайланд тусгадаг, нягтлан бодогчийн бүртгэлээр хэрэгжүүлэх хяналт хангалтгүй байна.

*Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодогч нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах үүрэгтэй” гэсэн заалтта нийцүүлж нягтлан бодогч бараа материалын тайланд хяналт хэрэгжүүлж, анхан шатны баримтын бүрдлийг хууль, журамд нийцүүлэн хангуулж ажиллах.*

2. ***Төсвийн гүйцэтгэл, зарцуулалттай  холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Халаалтын зардлаас ажилчдад түлшний хөнгөлөлт олгож, халаалтын зардлаар буруу тайлагнасан.

*Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцүүлэн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнах.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар  сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс: Залруулга | | Үүнээс: Төлбөрийн акт | | Үүнээс: Албан шаардлага | | Үүнээс: Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мэргэжлийн хяналтын газар | 3 | 2549.0 | 1 | 0 | | | | | 2 | 2549.0 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН**:

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:** **Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:** **А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН**:

**АУДИТОР:** **Б.ДОЛЖИНЖАВ**

Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

*заалттай нийцүүлж нягтлан бодогч бараа материалын тайланд хяналт хэрэгжүүлж, анхан шатны баримтын бүрдлийг хууль, журамд нийцүүлэн хангуулж ажиллах.*

***2. Төсвийн гүйцэтгэл, зарцуулалттай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Халаалтын зардлаас ажилчдад түлшний хөнгөлөлт олгож, халаалтын зардлаар буруу тайлагнасан.

*Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцүүлэн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнах.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Мэргэжлийн хяналтын газар | 3 | 2549.0 | 1 | 0 | | | | | 2 | 2549.0 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:** **Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:** **А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**АУДИТОР:** **Б.ДОЛЖИНЖАВ**

151 гүйлгээ 1,523,321.0